



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 284

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2, 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Дулааны гуравдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид сэргээн засварлах боломжгүй болсон 23,114,984.45 (хорин турван сая нэг зуун арван дөрвөн мянга есэн зуун наян дөрвөн төгрөг дөчин таван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, “Дулааны гуравдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Дамдинсүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА



0001925

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны об дугаар сарын 24-ны өдрийн  
2018-дугаар тогтоолын хавсралт

"Дулааны гуравдугаар цахилгаан станц" төрийн өмчт хувьцаат компанийн  
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашини жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэр лэсэн/ ашиглал тад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ /төгрөг/	Хууримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэх өртөг /төгрөг/	Сэргээн босголтын зардал /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/
1	Фотон-Autopan truck, 87-93 УБӨ, ачааны, 709508, LVBV CAD647J026450	2007	97759	22,160,439.00	22,160,439.00	0	0	3,000,000.00
2	Мустанг-5 мотоцикль, 72-08 УБ	2010	19075	954,545.45	954,545.45	0	0	250,000.00
				23,114,984.45 (хорин гурван сая нэг зуун арван дөрвөн мяняга есөн зуун наян дөрвөн төгрөг дөчин таван мөнгө)	23,114,984.45 (хорин гурван сая нэг зуун арван дөрвөн мяняга есөн зуун наян дөрвөн төгрөг дөчин таван мөнгө)			3,250,000.00 (гурван сая хоёр зуун тавин мяняган)
				Нийт дүн				